



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг (Багануур, Багахангай)-т анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-д зөвлөж, Сангийн яам (Б.Жавхлан), Зээлийн батлан даалтын сан (С.Цогтсайхан)-д тус тус даалгасугай.

2. Төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд Засгийн газар хариуцан төлөх хүүгийн татаасын хэмжээг арилжааны банкуудтай хэлэлцээрийн замаар санхүүжилтийн ерөнхий гэрээг холбогдох бусад байгууллагатай байгуулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулахыг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-д зөвлөж, Сангийн яам (Б.Жавхлан)-д даалгасугай.

3. Татан буугдсан мэргэжлийн хяналтын байгууллагын эзэмшлийн зарим аймаг дахь газрыг орон нутагт шилжин суурьшсан иргэдэд зориулсан орон сууцны барилга барих, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалтаар шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

4. Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах ажлын хүрээнд орон нутагт шилжин суурьших иргэдэд тодорхой урамшуулал олгоход, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн яам (Ч.Хүрэлбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Б.Бат-Эрдэнэ), Сангийн яам (Б.Жавхлан), Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Д.Амарбаясгалан)-т тус тус даалгасугай.

5.Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

6.“Хөдөөгийн сэргэлт” Үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл доор 2023 оны 03 дугаар сард багтаан зохион байгуулахыг Батлан хамгаалахын дэд сайд, “Хот, хөдөөгийн сэргэлт” Ажлын хэсэг (Б.Баярмагнай)-т даалгаж, тус чуулганд шаардагдах 400.0 (дөрвөн зуун) сая төгрөг хүртэлх хөрөнгийг гүйцэтгэлээр нь хянаж Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн яам (Б.Жавхлан)-д зөвшөөрсүгэй.

7.Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН